

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“МИК Холдинг” ХК, 9010001134, MSE:MIK, 11-328267
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Санхүүгийн бусад үйл ажиллагаа
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Эрнст энд Янг Монголия Аудит ХХК 2006-02-23
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	20,709,320
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Гантулга
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт Тайлан хавсаргав.
	Орлогын тайлан Тайлан хавсаргав.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан Тайлан хавсаргав.
	Мөнгөн гүйлгээний тайлан Тайлан хавсаргав.
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ыан дагуу материаллаг алдаагүй, бодитой толилуулсан байна.

1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/																										
	Байхгүй																										
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл																										
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/																										
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт																										
	<table border="1"> <thead> <tr> <th colspan="2">Санхүүгийн үзүүлэлтүүд</th> </tr> </thead> <tbody> <tr> <td colspan="2">Ашигт ажиллагаа</td> </tr> <tr> <td>Цэвэр хүүний маржин (NIM) *</td> <td>0.16%</td> </tr> <tr> <td>Нийт хөрөнгийн өгөөж (ROA) *</td> <td>-0.46%</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) *</td> <td>-0.46%</td> </tr> <tr> <td colspan="2">Өөрчлөлтийн хувь (оны эхнээс)</td> </tr> <tr> <td>Нийт активын өөрчлөлт</td> <td>-0.34%</td> </tr> <tr> <td>Зээлийн багцын өөрчлөлт</td> <td></td> </tr> <tr> <td colspan="2">Хөрөнгөнд эзлэх хувь</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө</td> <td>98.63%</td> </tr> <tr> <td>Өр төлбөр/Нийт хөрөнгө</td> <td>1.37%</td> </tr> <tr> <td colspan="2">Хөрвөх чадварын харьцаа</td> </tr> <tr> <td>Хөрвөх чадвартай хөрөнгө / Татан төвлөрүүлсэн хөрөнгө</td> <td>133.51%</td> </tr> </tbody> </table>	Санхүүгийн үзүүлэлтүүд		Ашигт ажиллагаа		Цэвэр хүүний маржин (NIM) *	0.16%	Нийт хөрөнгийн өгөөж (ROA) *	-0.46%	Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) *	-0.46%	Өөрчлөлтийн хувь (оны эхнээс)		Нийт активын өөрчлөлт	-0.34%	Зээлийн багцын өөрчлөлт		Хөрөнгөнд эзлэх хувь		Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	98.63%	Өр төлбөр/Нийт хөрөнгө	1.37%	Хөрвөх чадварын харьцаа		Хөрвөх чадвартай хөрөнгө / Татан төвлөрүүлсэн хөрөнгө	133.51%
Санхүүгийн үзүүлэлтүүд																											
Ашигт ажиллагаа																											
Цэвэр хүүний маржин (NIM) *	0.16%																										
Нийт хөрөнгийн өгөөж (ROA) *	-0.46%																										
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) *	-0.46%																										
Өөрчлөлтийн хувь (оны эхнээс)																											
Нийт активын өөрчлөлт	-0.34%																										
Зээлийн багцын өөрчлөлт																											
Хөрөнгөнд эзлэх хувь																											
Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	98.63%																										
Өр төлбөр/Нийт хөрөнгө	1.37%																										
Хөрвөх чадварын харьцаа																											
Хөрвөх чадвартай хөрөнгө / Татан төвлөрүүлсэн хөрөнгө	133.51%																										
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл																										
	Монгол улсын эдийг засаг 2025 онд 6.84 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан бөгөөд энэ нь нийт эдийн засгийн түвшин тогтвортой идэвхжиж буйг харуулж байна. Харин инфляцын түвшин жилийн 7.5 хувьд хүрч буурч өрхийн сарын дундаж орлого 15.5 хувиар, улсын дундаж нэрлэсэн цалин 7.7 хувиар нэмэгдсэн нь өрхийн санхүүгийн байдалд эергээр нөлөөлж, ипотекийн зээлийн төлөх чадамж болон орон сууц худалдан авах боломжийг сайжруулах эерэг төлөвтэй байна. Санхүүгийн салбарын хувьд өсөлт үргэлжилж, үйл ажиллагаа явуулж буй банкнуудын нийт актив 19.9 хувиар, банк бус санхүүгийн байгууллагуудын актив 27.4 хувиар тус тус өссөн нь салбарын тогтвортой байдлыг нэмэгдүүлж, компанийн харилцагч талын эрсдэлийг бууруулахад эергээр нөлөөлж байна. 2025 оны 12 сарын байдлаар орон сууцны үнийн индекс 2022 оны 12 сартай																										

харьцуулахад 1.38 болж, өмнөх оны мөн үеэс 12.2 хувиар өссөн ба сүүлийн жилүүдэд орон сууцны үнийн индексийн (ОСҮИ) өсөлт тогтвортой өсөж байгааг харуулж байна. Монгол улсын хүн амын бүтцэд залуучуудын эзлэх хувь их байгаа болон гэр хорооллыг дахин төлөвлөх, орон нутгийг орон сууцжуулах хэрэгцээ өндөр байгаатай холбоотой орон сууцны эрэлт өндөр байна.

2025 онд 25,817 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан ба энэ нь түүхэн дээд үзүүлэлт байсан. Мөн тус үзүүлэлт нь өмнөх оноос 30.45 хувиар өссөн, сүүлийн 5 жилд 82.2%-иар өссөн үзүүлэлт юм. Барилгын салбарын үйлдвэрлэл 2025 онд 28%-иар өссөн байдалтай байна.

2025 оны эцсийн байдлаар Засгийн газрын орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд олгосон ипотекийн зээлийн нийт үлдэгдэл 6.85 их наяд төгрөг, зээлдэгчдийн тоо 94.3 мянгад хүрсэн байна. “МИК ОССК” ХХК нь уг зээлийн 77.8%-ийг худалдан авч, үнэт цаасжуулаад байна. 2025 онд нийт 3,304.4 тэрбум төгрөгийн ипотекийн зээл ба үүний 37.3 хувь буюу 1,231.9 тэрбум төгрөгийн зээл нь ЗГОСИЗХ-ийн хүрээнд, 62.7 хувь буюу 2,072.5 тэрбум төгрөгийн зээл банкны болон бусад эх үүсвэрээр олгогдсон байна. 2024 онтой харьцуулахад, хөтөлбөрийн хүрээнд шинээр олгосон зээлийн хэмжээ 10.3 хувиар буурсан байна. Зээлийн хойшлуулалтын хөтөлбөрийн хүрээнд “МИК ОССК” ХХК нь давхардсан тоогоор 190.5 мянган зээлдэгчийн 10.1 их наяд төгрөгийн зээлийн төлбөрийг хойшлуулсан. Зах зээлийн хүүтэй ипотекийн зээл 33.0%-иар өссөн нь ипотекийн зээлийн нийлүүлэлт өссөн, эрэлт өндөр байгааг харуулж байгаа ба ипотекийн зээлийн зах зээлийн өсөлтөд эергээр нөлөөлж байна.

Улаанбаатар хотын агаар, хөрс, усны бохирдлыг бууруулахын тулд гэр хорооллыг дахин төлөвлөх, орон нутгийг орон сууцжуулах нь тулгамдсан асуудлуудын нэг болоод байна. Түүнчлэн Дэлхий нийтийн тогтвортой хөгжил, Байгаль орчин, нийгмийн засаглалын чиг хандлагын хүрээнд тогтвортой хөгжлийн санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотойгоор “МИК ОССК” ХХК нь “Тогтвортой хөгжлийн бодлого”-ыг батлан ногоон орон сууцны хөрөнгө, байгууламжуудыг үнэт цаасжуулах, гэр хорооллыг орон сууцжуулах, иргэдийн орлогод нийцсэн зээлийн бүтээгдэхүүнүүдийг төрөлжүүлэх, жендерийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг тавин ажиллаж байна.

Монгол Улс нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээгээр дэлхийд гуравт жагсдаг боловч хүн амын 50 орчим хувь нь нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзлэх нийслэл Улаанбаатар хотод төвлөрсөн байна. Иймд нийслэл, орон нутагт хөтөлбөрийн зээлийг тэгш хүртээмжтэй хуваарилах зорилгоор 2024 оноос орон нутагт олгох хөтөлбөрийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 2018-2022 онуудад олгосон нийт зээлийн дүнгийн дунджаар 17 хувийг, зээлдэгчдийн тоогоор дунджаар 24 хувийг орон нутагт олгосон бол 2023 онд хөтөлбөрийн зээлийг 8.9 мянган өрхөд олгосноос 32 хувийг буюу 302.6 тэрбум төгрөгийн зээлийг орон нутагт орон сууц худалдан авч буй 3.7 мянган өрхөд олгосон. Харин 2025 онд орон нутагт 419.1 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд энэ нь нийт зээлийн 34%-ийг бүрдүүлж байна.

Төрөөс баримтлах мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлд Хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг Монгол банкнаас Засгийн газарт шилжүүлэхээр тусгасан ба “МИК ОССК” ХХК нь Хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөр тогтвортой, үр ашигтайгаар үргэлжлэхэд Засгийн газартай хамтран ажиллана.

Орон сууцны ипотекийн хөтөлбөрийг Засгийн газар шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхээр заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А-246 дугаар тушаалаар “Банканд ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн зээл олгох түр журам”-ыг баталсан. Журмын хүрээнд хөтөлбөрт оролцогч талууд болох МИК ОССК ХХК болон банкнуудтай 2025 оны 2 дугаар сарын 18-ны өдөр “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г шинэчлэн байгуулж хөтөлбөрийн санхүүжилтийг Монголбанк өөрийн эзэмшлийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын эргэн төлөлтөөр хэвийн үргэлжлүүлж байна.

“Хуримтлалын сангаас орон сууцны ипотекийн хөтөлбөрт хөрөнгө оруулах ерөнхий гэрээнд өөрчлөлт оруулах гэрээ”-г байгуулж, нийт гаргасан ИЗББ I-ын 80 хувьтай тэнцүү, купоны хэмжээ 2.25% байх давуу эрхтэй ИЗББ-г Засгийн газар худалдан авч орон сууцны санхүүжилтийн эх үүсвэрийг төлөхөөр зохицуулсан.

Монгол Улс хүн амын насжилт залуу, социал орчинд идэвхтэй, ухаалаг утасны хэрэглээ өндөр, төрийн болон бусад цахим үйлчилгээнүүд нэмэгдэж байгаа энэ үед Компани хэрэглэгч, зээлдэгчдийн ажиллагааг

		<p>хөнгөвчилж барьцаа хөрөнгийг цахимаар чөлөөлөх, зээлдэгчийн зарим хүсэлтийг цахимаар шийдвэрлэж ажлыг эхлүүлсэн. Мөн дотоод үйл ажиллагаандаа цахим хэрэгсэл, инновацыг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд энэ ажлын хүрээнд санхүүгийн системийн шинэчлэл, багц худалдан авах үйл ажиллагааг цахимжуулах, “business intelligence tools” нэвтрүүлэхээр ажиллаж байна.</p> <p>“МИК ОССК” ХХК нь 2026 онд 900 тэрбум төгрөг хүртэлх дүн бүхий ипотекийн зээлийг багцлан худалдан авч үнэт цаасжуулахаар төлөвлөж байна.</p> <p>2026 онд “МИК ОССК” ХХК-ийн худалдан авч багцалдаг хөтөлбөрийн зээлийн бүтээгдэхүүний нөхцөлд орон нутагт чиглэсэн дараах арга хэмжээг авна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Орон нутагт олгогдох зээлийн хэмжээний дээд хязгаар 150 сая төгрөг; ▪ Орон нутагт даатгагч зээлийн урьдчилгаа төлбөрт батлан даалт гаргах боломжтой; <p>2023 оноос хэрэгжсэн, орон нутаг болон алслагдмал дүүргүүдэд орон сууц худалдан авах иргэдийн урьдчилгаа төлбөрт баталгаа гаргах, 3 хувийн хүүгийн татаас олгох зэрэг арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.</p>
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Мэдээ хавсаргав.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	<p>Тайлант хугацаанд тусгай зориулалтын 3 компаниар дамжуулан, нийт 1,681.3 тэрбум төгрөгийн дүн бүхий 15,620 хөтөлбөрийн ипотекийн зээлийг худалдан авсан.</p> <p>Засгийн газрын 2023 оны “Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолын дагуу Монголбанк, Барилга хот байгуулалтын яам, Зээлийн батлан даалтын сан болон Арилжааны банкнууд “Ипотекийн зээл”-ийн орон нутгийн орон сууцны санхүүжилтийн ерөнхий гэрээ байгуулсан ба тус гэрээний дагуу банкнууд орон нутагт болон алслагдсан дүүргүүдэд (Налайх, Багануур, Багахангай) урьдчилгаа төлбөрийн батлан даалттай</p>

		ипотекийн зээлүүдийг олгож эхэлсэн. “МИК ОССК” ХХК нь 2025 онд Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 1,681.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргасан бөгөөд үүнээс 116.5 тэрбум төгрөгийн 1105 зээл нь урьдчилгаа төлбөрийн батлан даалттай зээл байна.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	<ol style="list-style-type: none"> 1. 1/20/2025 - Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ - Худалдаа хөгжлийн банк – Хадгаламж байршуулах 2. 3/12/2025 - Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ - Худалдаа хөгжлийн банк – Хадгаламж байршуулах 3. 2/7/2025 – Түрээсийн гэрээ – “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК – Оффис түрээслэх 4. 4/17/2025 - Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ - Худалдаа хөгжлийн банк – Хадгаламж байршуулах 5. 5/12/2025 - Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ - Худалдаа хөгжлийн банк – Хадгаламж байршуулах 6. 6/11/2025 - Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ - Худалдаа хөгжлийн банк – Хадгаламж байршуулах 7. 7/24/2025 - Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ - Худалдаа хөгжлийн банк – Хадгаламж байршуулах 8. 9/8/2025 - Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ - Худалдаа хөгжлийн банк – Хадгаламж байршуулах 9. 10/15/2025 - Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ - Худалдаа хөгжлийн банк – Хадгаламж байршуулах 10. 11/14/2025 - Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ - Худалдаа хөгжлийн банк – Хадгаламж байршуулах 11. 12/17/2025 - Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ - Худалдаа хөгжлийн банк – Хадгаламж байршуулах 	
4.	Цалин урамшууллын мэдээлэл	
	“МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025.04.30-ны өдрийн ээлжит хурлын 25/02 дугаартай тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн зардлын төсвийг баталсан. Мөн Гүйцэтгэх удирдлагад олгох цалин урамшууллын Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоодог бөгөөд санхүүгийн жилд Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүд, Гүйцэтгэх удирдлагад олгосон цалин, урамшууллын талаар дэлгэрэнгүйг хавсралт дахь “Компанийн засаглалын тайлан”-аас үзнэ үү.	
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	

	Санхүүгийн жилд хамаарах компанийн засаглалтай холбоотой мэдээллийг хавсралт дахь “Компанийн засаглалын тайлан”-аас үзнэ үү.																												
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл																												
	МИК Холдинг ХК-ийн зах зээлийн эрсдэл түүний охин компаниудад тулгамдаж буй гадаад болон дотоод эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой. Монгол Улсын эдийн засаг 2025 онд 6.8 хувийн өсөлт үзүүлсэн ба Монголбанкны зүгээс АНУ-ын тарифын нөлөө шинжээчдийн хүлээлтээс харьцангуй бага нөлөөтэй байгаагаас гадна дэлхийн болон БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн түвшин нэмэгдсэн, дэлхийн зах зээл дэх алт болон зэсийн үнэ хүлээлтээс өндөр байгаатай холбоотой бодлогын хүүг 12%-д хэвээр үлдээсэн. Гэсэн хэдий ч 2026 онд хэрэглээний зээлийн өсөлт эрэлтийн шалтгаантай инфляци болон импортыг нэмэгдүүлэх, ханш, төлбөрийн тэнцлийн дарамтыг нэмэгдүүлэх төсөөлөлтэй байгаа нь үнэт цаасжуулсан багцын зээлдэгч нарын зээл эргэн төлөх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй байна . 2025 оны байдлаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3,556.81 төгрөгтэй тэнцэж оны эхнээс 4%-иар суларсан үзүүлэлттэй байна. Энэ нь компанийн ам.долларын эх үүсвэрийн эргэн төлөлтөд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.																												
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/																												
	<p>“МИК Холдинг” ХК нь санхүүгийн жилийн эцсийн байдлаар нийт 240 хувьцаа эзэмшигчидтэй байсан бөгөөд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид буюу тав ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшлийн хэмжээг дараах хүснэгтэд тусгав.</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Хувьцаа эзэмшигчдийн нэрс</th> <th>Хувьцааны тоо ширхэг</th> <th>Хувь хэмжээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Монгол Улсын Хөгжлийн Банк</td> <td>3,081,955</td> <td>14.88 %</td> </tr> <tr> <td>2</td> <td>“Си Эн Би Консалтинг” ХХК</td> <td>2,608,480</td> <td>12.60%</td> </tr> <tr> <td>3</td> <td>“Азиа Дайверсифайд Рийл Истэйт Фанд Нэг Хувийн ХОС” ХХК</td> <td>2,312,500</td> <td>11.17%</td> </tr> <tr> <td>4</td> <td>“Худалдаа хөгжлийн банк” ХК</td> <td>2,070,932</td> <td>10.00 %</td> </tr> <tr> <td>5</td> <td>“Ти Ди Би Капитал” ХХК</td> <td>1,232,785</td> <td>5.95%</td> </tr> <tr> <td>6</td> <td>“Ти Ди Би Секьюритиз УЦК” ХХК</td> <td>1,097,953</td> <td>5.30 %</td> </tr> </tbody> </table>	№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Хувьцааны тоо ширхэг	Хувь хэмжээ	1	Монгол Улсын Хөгжлийн Банк	3,081,955	14.88 %	2	“Си Эн Би Консалтинг” ХХК	2,608,480	12.60%	3	“Азиа Дайверсифайд Рийл Истэйт Фанд Нэг Хувийн ХОС” ХХК	2,312,500	11.17%	4	“Худалдаа хөгжлийн банк” ХК	2,070,932	10.00 %	5	“Ти Ди Би Капитал” ХХК	1,232,785	5.95%	6	“Ти Ди Би Секьюритиз УЦК” ХХК	1,097,953	5.30 %
№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Хувьцааны тоо ширхэг	Хувь хэмжээ																										
1	Монгол Улсын Хөгжлийн Банк	3,081,955	14.88 %																										
2	“Си Эн Би Консалтинг” ХХК	2,608,480	12.60%																										
3	“Азиа Дайверсифайд Рийл Истэйт Фанд Нэг Хувийн ХОС” ХХК	2,312,500	11.17%																										
4	“Худалдаа хөгжлийн банк” ХК	2,070,932	10.00 %																										
5	“Ти Ди Би Капитал” ХХК	1,232,785	5.95%																										
6	“Ти Ди Би Секьюритиз УЦК” ХХК	1,097,953	5.30 %																										
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл																												
	МИК Холдинг” ХК нь тайлант хугацаанд нийтэд санал болгон хувьцаа нэмж гаргаагүй болно.																												
9.	Ногдол ашгийн мэдээлэл																												

МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 25/04 дугаартай тогтоолоор хувьцаа эзэмшигчдэд 2025 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2015 оны 15/03 дугаартай тогтоолоор компанийн “Ногдол ашгийн бодлого”-ыг баталсан бөгөөд компанийн цахим хуудсаар дамжуулж тус баримт бичигтэй дэлгэрэнгүй танилцах боломжтой.

Тус бодлогын хүрээнд, олон улсын зах зээлд гаргасан “Бондын нөхцөлийн гэрээ”-ний дагуу ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосон бөгөөд хувьцаа эзэмшигчдэд тус шийдвэрийн үндэслэлийн талаар “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлын хэлэлцэх асуудлын дагуу танилцуулсан болно.

10. Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

1. 2025 он Цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах төвийн хүсэлтээр Зүрхний бүрэн автомат цахилгаан бичлэгийн аппарат, Ясны чөмгөний биопсийн болон хатгалтын нэг удаагийн зориулалтай зүү болон эмч ажилтнуудын амралтын өрөөний тохижилтод мөнгөн хандив өгөв. Ингэснээр цусны хорт хавдар болон чөмөг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэх гэж байгаа иргэдийн шинжилгээ оношилгоо хийлгэх болон эмч, сувилагч нарын тусламж үйлчилгээний чанар сайжрав.
2. 2025 оны 8-р сарын 8-ны өдрөөс 9-р сарын 8-ны өдөр “Чингис Хаан” үндэсний музейд “Их шүтээн: Эзэн Чингис Хаан” тухай үзэсгэлэнг зохион байгуулах ажилд ивээн тэтгэсэн.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Гантулга

Албан тушаал: МИК Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



Мэдээлэл бэлтгэж, хүргүүдсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Саруул

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Регистрийн дугаар:

5	2	2	1	9	7	8
---	---	---	---	---	---	---

Хаяг : Чингэлтэй дүүрэг 1-р хороо Бага тойруу /15160/ Д.Сүхбаатарын гудамж – 11 тоот барилга

Шуудангийн хаяг : Ш/х - 686

Утас : 328267, 70118267

Факс : 313338

Өмчийн хэлбэр : Төрийн 17,23%

Хувийн 82,77 %.



**“МИК ХОЛДИНГ” ХК -ИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар, өдөр	Гарын үсэг

**“МИК ХОЛДИНГ” ХК-ийн
2025 оны санхүүгийн тайлангийн
бодит байдлын тухай мэдэгдэл**

2025 оны 12 сарын 31 өдөр

Гүйцэтгэх Захирал Б.Гантулга, Санхүү хариуцсан дэд захирал М.Золжаргал, Санхүүгийн удирдлагын газрын захирал Ц.Энхзул бид манай аж ахуйн нэгжийн 2025 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 18.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

7. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан
8. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн
9. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан
10. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй
11. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан
12. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Гүйцэтгэх захирал

Санхүү хариуцсан дэд захирал

СУГазрын захирал



/Б.ГАНТУЛГА/

/М.ЗОЛЖАРГАЛ/

/Ц.ЭНХЗУЛ/

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

"МИК Холдинг" ХК

/Аж ахуйн нэгжийн нэр/

/Төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,751,979,658.00	1,369,240,772.17
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	50,743,925.65	50,743,925.65
1.1.4	Бусад авлага	91,404,828.78	220,704,384.90
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	4,034,120.00	4,034,120.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/гооцоо	2,478,163.37	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,900,640,695.80	1,644,723,202.72
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	21,826,050.75	23,825,014.04
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	73,075,104,539.64	73,075,104,539.64
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	73,096,930,590.39	73,098,929,553.68
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	74,997,571,286.19	74,743,652,756.40
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	4,421,483.58	14,888,731.01
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	86,044,595.83	38,982,160.93
2.1.1.4	НДШимтгэлийн өглөг	916,602.57	916,602.57
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	844,886,950.59	970,799,121.56
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) -нд хамаарах өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	936,269,632.57	1,025,586,616.07
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	936,269,632.57	1,025,586,616.07
2.2	Өр төлбөрийн нийт дүн	936,269,632.57	1,025,586,616.07
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч : - төрийн		
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат	20,709,320,000.00	20,709,320,000.00
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	52,225,114,830.04	52,225,114,830.04
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Галаад валютын хөрвүүлдэх нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	1,453,134,500.71	1,126,866,823.58
2.3.10	Тайлан үеийн ашиг /алдагдал/	(326,267,677.13)	(343,235,513.29)
2.3.11	Эздийн өмчийн дүн	74,061,301,653.62	73,718,066,140.33
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	74,997,571,286.19	74,743,652,756.40

Гүйцэтгэх захирал..... /Б.Гантулга/
 Санхүү хариуцсан дэд захирал..... /М.Золжаргал/
 Санхүүгийн удирдлагын газрын захирал..... /Ц.Энхзул/
 ТБХХэлтсийн захирал..... /А.Цолмон/
 Санхүүгийн ахлах мэргэжилтэн..... /Д.Түвшинболор/
 Санхүүгийн хяналтын мэргэжилтэн..... /М.Анхбаяр/



ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

"МИК Холдинг" ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

/Төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)		
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	154,690,435.16	118,337,872.54
6	Ноогдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,576,368,158.24	759,152,146.06
9	Борлуулалт, маркетингийн зардал	(4,465,454.55)	(4,909,090.89)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(1,184,688,887.88)	(1,055,593,904.77)
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	(852,702,884.58)	(148,388,748.98)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(310,798,633.61)	(331,401,726.04)
19	Орлогын татварын зардал	(15,469,043.52)	(11,833,787.25)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(326,267,677.13)	(343,235,513.29)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	(326,267,677.13)	(343,235,513.29)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(326,267,677.13)	(343,235,513.29)
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

Гүйцэтгэх захирал:.....  /Б.Гантулга/
 Санхүү хариуцсан дэд захирал  /М.Золжаргал/
 Санхүүгийн удирдлагын газрын захирал  /Ц.Энхзул/
 ТБХХэлтсийн захирал  /А.Цолмон/
 Санхүүгийн ахлах мэргэжилтэн  /Д.Түвшинболор/
 Санхүүгийн хяналтын мэргэжилтэн  /М.Анхбаяр/



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

"МИК Холдинг" ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

/Төгрөг/

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэх нөөц	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	20,709,320,000.0	-	52,225,114,830.0	-	-	-	1,453,134,500.00	74,387,569,330.04
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	20,709,320,000.0	-	52,225,114,830.0	-	-	-	1,453,134,500.71	74,387,569,330.75
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(326,267,677.13)	(326,267,677.13)
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт								-
7	Зарласан ноогдол ашиг								-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
9	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	20,709,320,000.0	-	52,225,114,830.04	-	-	-	1,126,866,823.58	74,061,301,653.62
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	20,709,320,000.0	-	52,225,114,830.04	-	-	-	1,126,866,823.58	74,061,301,653.62
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(343,235,513.29)	(343,235,513.29)
13	Бусад дэлгэрэнгүй орлого								-
14	Өмчид гарсан өөрчлөлт								-
15	Зарласан ноогдол ашиг								-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
17	2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	20,709,320,000.0	-	52,225,114,830.0	-	-	-	783,631,310.29	73,718,066,140.33

Гүйцэтгэх захирал:..... /Б.Гантулга/

Санхүү хариуцсан дэд захирал /М.Золжаргал/

Санхүүгийн удирдлагын газрын захирал /Ц.Энхзул/

ТБХХэлтсийн захирал /А.Цолмон/

Санхүүгийн ахлах мэргэжилтэн /Д.Түвшинболор/

Санхүүгийн хяналтын мэргэжилтэн /М.Анхбаяр/




МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

"МИК Холдинг" ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

/Төрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,124,312,816.15	824,953,577.21
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	1,124,312,816.15	824,953,577.21
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,364,285,769.45	1,207,692,463.04
	Ажиллагчдад төлсөн	794,178,443.75	732,197,619.31
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	193,405,739.45	178,029,469.42
	Бараа, материал худалдан авахад төлсөн		
	Ашиглалтын зардалд төлсөн		
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	287,024,163.64	207,717,466.02
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	89,677,422.62	89,747,908.29
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(239,972,953.30)	(382,738,885.83)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ноогдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(239,972,953.30)	(382,738,885.83)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,991,952,611.30	1,751,979,658.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,751,979,658.00	1,369,240,772.17

Гүйцэтгэх захирал:  /Б.Ганболд/
 Санхүү хариуцсан дэд захирал:  /М.Золжаргал/
 Санхүүгийн удирдлагын газрын захирал:  /Д.Энхзул/
 ТБХХэлтсийн захирал:  /А.Долмонт/
 Санхүүгийн ахлах мэргэжилтэн:  /Д.Түвшинболор/
 Санхүүгийн хяналтын мэргэжилтэн:  /М.Анхбаяр/



Тэнцлийн гадуурх дансны үлдэгдлийн дэлгэрэнгүй мэдээ

Дугаар	Дансны дугаар	Дансны нэр	Эзэмшигч	Эзэмшигч нэр	Нээсэн огноо	Хаасан огноо	Үлдэгдэл
Салбар		190	МИК ХОЛДИНГ				
	Бүтээгдэхүүн:	6004000000		ЗАРЛАСАН ЭНГИЙН ХУВЬЦАА			9,290,680.00
	Валют:	MNT					
1	1900000002	ЗАРЛАСАН ЭНГИЙН ХУВЬЦАА	9000026759	МИК ХОЛДИНГ ХХК	2015-12-02		9,290,680.00
	Бүтээгдэхүүн:	6005000000		БОРЛУУЛСАН ЭНГИЙН ХУВЬЦАА			20,709,320.00
	Валют:	MNT					
2	1900000004	ТӨРИЙН БАНК	9020006126	ТӨРИЙН БАНК	2015-12-02		486,951.00
3	1900000076	БОР/ЭНГИЙН ХУВЬЦАА ТИДИБИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК	9900000004	ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК	2022-12-31		1,097,953.00
4	1900000062	МИК АКТИВ ХОЁР ТЗК ХХК	9020017663	МИК АКТИВ ХОЁР ТЗК ХХК	2018-12-31		432,712.00
5	1900000006	ГОЛОМТ БАНК	9020006118	ГОЛОМТ БАНК	2015-12-02		1,023,033.00
6	1900000060	НЕКСУС ФИНАНС ИНВЕСТМЕНТ ХХК	9900000002	НЕКСУС ФИНАНС ИНВЕСТМЕНТ ХХК	2018-12-31		117,379.00
7	1900000010	ХАС БАНК	9020006119	ХАС БАНК	2015-12-02		210,621.00
8	1900000064	СИ И СИ ГРУПП ХХК	9000033144	СИ И СИ ГРУПП	2020-12-31		488,750.00
9	1900000058	ЖИЖИГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД	9000026758	МИК ОССК ХХК	2016-04-30		32,661.00
10	1900000008	КАПИТРОН БАНК	9020006122	КАПИТРОН БАНК	2015-12-02		210,631.00
11	1900000013	ЧИНГИС ХААН БАНК	9020006124	ЧИНГИС ХААН БАНК	2015-12-02		61,639.00
12	1900000009	ХААН БАНК	9020006116	ХААН БАНК	2015-12-02		210,621.00
13	1900000061	МИК АКТИВ НЭГ ТЗК ХХК	9010007659	МИК АКТИВ НЭГ ТЗК ХХК	2018-12-31		892,927.00
14	1900000011	ХХБ	9020006117	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	2015-12-02		6,452,412.00
15	1900000065	СИ ЭН БИ КОНСАЛТИНГ	9000033145	СИ ЭН БИ КОНСАЛТИНГ	2020-12-31		539,500.00
16	1900000055	БОР/ЭНГИЙН ХУВЬЦАА ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	9000026776	ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	2015-12-24		1,232,785.00
17	1900000005	ХӨГЖЛИЙН БАНК	1000026756	ХӨГЖЛИЙН БАНК	2015-12-02		3,081,955.00
18	1900000015	МИК ОССК ХХК	9000026758	МИК ОССК ХХК	2015-12-02		4,136,790.00
	Бүтээгдэхүүн:	6007000000		ХЭРЭГЛЭЖ БАЙГАА ТАМГА, ТЭМДГҮҮД			1.00
	Валют:	MNT					
19	1900000059	МИК ХОЛДИНГ ХК-ТАМГА, ТЭМДГҮҮД	9000026759	МИК ХОЛДИНГ ХХК	2017-02-01		1.00
НИЙТ				MNT	65		30,000,001.00

БАЛАНСЫН ГАДУУРХ БҮРТГЭЛ

- 15.1. **Ерөнхий зүйл:** Компанийн хадгалсан үнэ бүхий зүйлсийг балансын гадуурхи бүртгэлд бүртгэнэ.
- 15.2. **Хадгалсан үнэ бүхий зүйлс:** Компанийн балансад бүртгэлгүй, эсхүл бүртгэлтэй байсан ч мөнгөн бус нэгжээр давхар бүртгэж, хяналт тавих зайлшгүй шаардлагатай үнэт цаас, нарийн бүртгэлтэй маягт, хөрөнгө эзэмшлийн болон бусад үнэ цэнэ бүхий баримт бичиг, Компанийн эзэмшлийн эрх зэрэг зүйлсийг балансын гадуур бүртгэж хяналт тавина.
- 15.3. Хадгалсан үнэ бүхий зүйлсийг дараах байдлаар ангилж бүртгэнэ:
- 15.3.1. **Барьцаанд авсан хөрөнгө:** Зээлдэгчээс зээлийн барьцаанд тавьсан хөрөнгө, хөрөнгө эзэмших эрхийг өнөөгийн үнэ цэнээр үнэлж, зээлдэгч нэг бүрээр бүртгэнэ. Барьцаа болон хүлээн авсан хөрөнгийн тэнцлийн гадуур
- Үнэ бүхий зүйлийн 62100004 дансанд тоо, ширхэгээр, Зээлийн барьцаа хөрөнгийн 63100006 дансанд үнийн дүнгээр зээлдэгч тус бүрээр данс нээж бүртгэнэ. Зээлдэгч зээл, авлагаа төлсөн тохиолдолд барьцаанд авсан хөрөнгийн тэнцлийн гадуурх данснаас зарлагдана.
- 15.3.2. **Хадгалсан үнэ бүхий зүйл:** Компанийн барилгын зураг, нарийн бүртгэлтэй маягт, бусад шаардлагатай зүйлсийг тоо ширхэг буюу үнээр нь бүртгэнэ. Хадгалсан зүйлсийн нэр төрөл буюу үйлчлүүлэгч, эзэмшигчийн нэрээр данс нээж бүртгэнэ.
- 15.3.3. **Борлуулсан үнэт цаас:** Компанийн гаргасан худалдсан үнэт цаасыг нэр төрлөөр ангилж, тоо ширхэгээр нь бүртгэнэ.
- Давуу эрхтэй болон энгийн эрхтэй бонд - Ипотекийн зээл худалдан авахад зориулан түүний үнийн төлбөрт Давуу эрхтэй болон Энгийн эрхтэй бонд бүхий орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаас.
- Компани бонд гаргах үед 62100002 дансанд давуу эрхтэй бондыг, 62100003 дансанд энгийн эрхтэй бондыг тоо ширхэгээр бүртгэнэ. Бонд төлөгдөх үед төлсөн бондын хэмжээгээр тэнцлийн гадуурх данснаас тоо ширхэгээр нь зарлагдана.
- 15.4. **Компанид ашиглагдаж буй тамга, тэмдэг:** Компанийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тамга, тэмдэг, лацны тэмдгийг нэр төрлөөр нь ангилж, тоо ширхэгээр бүртгэнэ.
- 15.5. **Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ бүртгэх:** Чанаргүй зээлийг бууруулах зорилгоор компанийн нэр дээр шилжүүлж авсан Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг үндэслэн тоо ширхэгээр бүртгэнэ
- 15.6. **Тэнцлийн гадуурх дансны нэгдсэн төлөвлөгөө, дансны бүтэц:** Тэнцлийн гадуурх дансны төлөвлөгөө нь бүлгийн данс, нэрийн данс, дэд данс гэсэн хэлбэртэй байна.
- 15.7. Тэнцлийн гадуурх дэд данс:
- 61 – Хүлээж болзошгүй үүрэг;
 - 62 – Үнэ бүхий зүйл;
 - 63 – Зээл болон бусад хөрөнгийн тооцоо;
 - 64 – Бусад тооцоо.
- 15.8. Тэнцлийн гадуурх дансны дугаар нь 10 оронтой байна. Дансны дугаарын эхний 2 орон нь дансны бүлгийг, 3, 4 дэх орон нэмэгдсэнээр тэнцлийн (ерөнхий дэвтрийн) данс, 5,6,7,8 дахь орон нэмэгдсэнээр дансны нарийвчилсан ангилалыг (бүтээгдэхүүн), 9,10 дахь орон нь харилцагийн сегмент кодыг илэрхийлнэ. Жишээлбэл:
- 62 – Үнэ бүхий зүйл;
 - 6210 – Үнэ бүхий зүйл ерөнхий дэвтрийн данс;
 - 6210 0002 – Үнэ бүхий зүйл Давуу эрхтэй бонд;
 - 6210 0002 11 – Үнэ бүхий зүйл Банк санхүүгийн байгууллагын эзэмшиж байгаа Давуу эрхтэй бонд.

*2025 оны жилийн үйл ажиллагааны
тайлангийн Хавсралт-1*

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

Тайланг бэлтгэсэн:

ТУЗ-ийн ажлын алба

Тайлангийн хамрах хугацаа:

2025.01.01-2025.12.31

Тайлан гаргасан огноо:

2026.03.01



АГУУЛГА

1. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАЙЛАН
2. ТУЗ-ИЙН АЖЛЫН АЛБАНЫ ТАЙЛАН (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга тайлан)



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

1. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

“МИК Холдинг” ХК-ийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хураас 6 ердийн 3 хараат нийт 9 гишүүнийг 3 жилийн хугацаатай сонгосон. ТУЗ-ийн гишүүд дунджаар мэргэжлийн салбартаа 18 жилийн ажлын туршлагатай, үүнээс 13 жил нь удирдах түвшинд ажилласан туршлагатай. Гишүүдийн ихэнх нь банк, санхүү, эдийн засгийн чиглэлийн мэргэжилтэй, дэд профессор, магистрын зэрэгтэй гишүүд байгаа нь боловсролын түвшин, мэргэжлийн ур чадвар өндөр байгааг илтгэж ТУЗ-ийн шийдвэр гаргах, хяналт тавих чадварыг нэмэгдүүлж байна.

№	ТУЗ	НЭР	АЖИЛ, АЛБАН ТУШААЛ
1	ТУЗ-ийн дарга, Хараат бус гишүүн	Чулуундоржийн Хашчулуун	Монгол Улсын Их Сургуулийн Дэд профессор
2	Ердийн гишүүн	Атарбаатарын Энхжин	Монгол Улсын Их Сургуулийн Дэд профессор
3	Ердийн гишүүн	Бат-Өлзийн Сайнзаяа	Монгол Улсын Хөгжлийн банкны Төслийн санхүүжилтийн газрын захирал
4	Ердийн гишүүн	Мягмарын Мөнхбаатар	Азиа Дайверсифайд Рийл Эстэйт Фанд Нэг” ХХК-ийн зөвлөх
5	Ердийн гишүүн	Товуудоржийн Даваажав	Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал
6	Ердийн гишүүн	Нямдоржийн Сэргэлэн	Худалдаа хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын орлогч
7	Ердийн гишүүн	Батцэнгэлийн Үүрцайхбаатар	Капитрон банкны Гүйцэтгэх захирал
8	Хараат бус гишүүн	Энхбаярын Шижир	Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийн удирдагч
9	Хараат бус гишүүн	Амаржаргалын Анар	"Синержи Фанд" ХХК-ийн Гүйцэтгэх захирал



2. ТУЗ-ИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

№	ТУЗ-ИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ	ХУРЛЫН	ХУРЛЫН ДУНДАЖ
		ТОО	ИРЦ
1	МИК Холдинг ХК-ийн хурал	10	79.2 %
2	“МИК ОССК” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал	1	88.8 %
3	МИК ОССК” ХХК-ийн ТУЗ-ийн хурал	11	79.2 %
4	МИК Рийл Эстэйт ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал	1	88.8 %
5	Тусгай зориулалтын компанийн (ТЗК) хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал	39	88.8 %

“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ нь түүний охин компани болох “МИК ОССК” ХХК, “Протега Фөрст” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурлын бүрэн эрхийг, “МИК Рийл Эстэйт” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг, “МИК ОССК” ХХК-ийн ТУЗ нь ТЗК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг дүрэмд заасны дагуу тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Үүнд: Санхүүгийн тайлан, Аудитын үйлчилгээний гэрээ байгуулах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, компанийн Бизнес төлөвлөгөө батлах, Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэлгээ, олон улсын зах зээл дээр үнэт цаас гаргахтай холбоотой баталгаа гаргах зэрэг асуудлыг хэлэлцлээ.

“МИК ОССК ХХК-ийн ТУЗ-ийн хурлаар ТЗК үүсгэн байгуулах, Үнэт цаасжуулалтын хэлцлийн нөхцөл тогтоох, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, олон улсын болон дотоодын зах зээл дээр үнэт цаас гаргах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

“МИК ОССК” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж, Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг хэлэлцэн баталлаа.

“МИК Рийл Эстэйт” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж, Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн гишүүн сонгох асуудлыг хэлэлцэн баталлаа.

ТЗК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох Компанийн дүрмийг шинэчилж батлах, Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.



3. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ТАЙЛАН

САНХҮҮ, АУДИТЫН ХОРОО	БҮРЭЛДЭХҮҮН	ХУРЛЫН ТОО	ХУРЛЫН ДУНДАЖ ИРЦ
НЭР ДЭВШҮҮЛЭХ, ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ХОРОО	Хорооны дарга: Э.Шижир Гишүүд: Т.Даваажав, Ч.Хашчулуун, А.Анар,	5	90%
	Хорооны дарга: Ч.Хашчулуун, Гишүүд: М.Мөнхбаатар, Ч.Хашчулуун А.Анар,	5	80%
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО	Хорооны дарга: А.Энхжин Гишүүд: Б.Сайнзаяа, Б.Үүрцайхбаатар, Н.Сэргэлэн,	3	83 %
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХОРОО	Хорооны дарга: Н.Сэргэлэн Гишүүд: А.Энхжин Э.Шижир,	3	88%

ТУЗ-ийн дэргэд байнгын үйл ажиллагаатай (4) хороо үйл ажиллагаа явуулж байна. Хорооны гишүүдийг ТУЗ-ийн гишүүдийн дотроос, хорооны даргыг томилогдсон хорооны гишүүдийн дотроос дийлэнх олонхын саналаар ТУЗ-ийн шийдвэрээр томилж, чөлөөлөлдөг. Санхүү, аудитын хороо, Нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хорооны гишүүдийн дийлэнх олонх нь мөн дарга нар нь хараат бус гишүүн байдаг.

Санхүү аудитын хороо

ТУЗ-д удирдах чиглүүлэх болон хянан шалгах үүргээ үр ашигтай, бүтээлчээр хийж гүйцэтгэхэд туслах, компанийн санхүүгийн төсөв, тайланд хяналт тавих, хөндлөнгийн аудитортай харилцан ажиллах, дотоод аудитын бодлого, журам зэргийг хангах асуудлыг хариуцна.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

- Компанийн санхүүгийн төсөв, төлөвлөгөө,
- Дотоод аудитын ажлын хөтөлбөр, тайлан
- Улирлын санхүүгийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан
- Хөндлөнгийн аудитын байгууллага сонгох

Эрсдэлийн удирдлагын хороо

ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ нь эрсдэлийн бодлого, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хязгаарт хяналт тавих, бизнесийн үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлийг хянах, дүгнэх асуудлыг хариуцна.



Хурлаар хэлэлцсэн асуудал:

- Эрсдэлийн удирдлагын тайлан
- Комплексийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан.

Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллыг хороо

Компанийн засаглалын тогтолцоо, түүнд хамаарах санхүү, дотоод хяналттай холбоотой баримт бичгээс бусад бодлого, дүрэм журам, тэдгээрийн өөрчлөлт, шинэчлэлт, хэрэгжилтэд хяналт тавих асуудал, ТУЗ-ийн гишүүн, ГУ болон ТУЗ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг албан тушаалтныг сонгон шалгаруулах, тавигдах шаардлагыг тодорхойлох, нэр дэвшүүлэх, тэдгээртэй байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах, ТУЗ болон ГУ-ын үйл ажиллагааг үнэлэх ажлыг зохион байгуулах, асуудал, ТУЗ-ийн гишүүн, ГУ болон ТУЗ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг албан тушаалтанд олгох цалин, урамшууллын бодлого, түүний хэрэгжилтэд хяналт тавих, тэдгээрт олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох, компанийн хүний нөөцийн бодлого, урамшууллын системийг тодорхойлж үр дүнг үнэлэх зэргийг хариуцна.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

- ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлт,
- ГУ-ын тайлан, цалин, урамшуулал,
- Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт,
- ТУЗ-ийн ажлын албаны тайлан
- Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт
- ТУЗ-ийн гишүүдэд олгох цалин, урамшуулал

Тогтвортой хөгжлийн хороо

ТУЗ-ийн дэргэдэх ТХХ нь компанийн тогтвортой хөгжлийн бодлого, стратеги болон зорилтуудыг тодорхойлж, тэдгээрийн гүйцэтгэлийг тогтмол сайжруулах, хэмжүүр үзүүлэлт, тайлагналд хяналт тавих асуудлыг хариуцна.

Тогтвортой хөгжлийн хорооны хурлаар Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцтай танилцаж ажиллаа.

4. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЦАЛИН

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин тогтмол болон нэмэгдэл цалингаас бүрддэг. Суурь цалин нь ТУЗ-ийн гишүүнээс томилогдон ажиллаж байгаагийн хувьд сар болгон олгогдох тогтмол цалин бөгөөд харин нэмэгдэл цалинг хуралд оролцсон оролцоо тус бүрээр тооцогдон улирал нэг удаа олгодог. Нэмэгдэл цалинг тооцоох аргачлалын боловсруулан ТУЗ-өөр батлуулсан.



2025 оны ТУЗ-ийн цалингийн зардлын төсөв:

Зардлын төрөл	Сарын цалин		Давтамж	Хүний тоо	Үүнээс:			
	суурь	нэмэгдэл			2025/05/01-2025/12/31		2026/01/01-2026/04/30	
					суурь	нэмэгдэл	суурь	нэмэгдэл
Цалин	700,000	500,000	12	9	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
ТУЗ-ийн гишүүн	700,000	500,000	12	9	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
НДШ	86,100	61,500	12	9	6,199,200	4,428,000	3,099,600	2,214,000
Нийт зардал	786,100	561,500	12	9	56,599,200	40,428,000	28,299,600	20,214,000

5. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төлөөлөн удирдах зөвлөлийн хэлэлцүүлэг

2026.03.02-ны өдөр Компанийн өнөөгийн нөхцөл, зах зээлийн төлөв байдал болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцүүлэх зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт компанийн удирдлагууд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд оролцож санал бодлоо солилцлоо.

Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэлгээ

Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэлгээний журмын дагуу 2026 оны 26/08 дугаартай тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааг үнэлэх ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэж, 2026.4.03-06 өдрийн хооронд үнэлгээ явууллаа. Үнэлгээг нарийвчилсан асуулгын хуудсуудаар цахимаар цуглуулж, зохион байгуулсан бөгөөд үнэлгээ 1-ээс 5 хүртэлх шатлалаар өгөгдсөн.

Үнэлгээний товч үр дүн

№	ТУЗ-ын үйл ажиллагааны үнэлгээ	Үнэлгээ
1	Ерөнхий үнэлгээ ба бүрэн эрхийн хэрэгжилт	4.51
2	ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн	4.56
3	ТУЗ-ийн үйл ажиллагаа	4.24
4	ТУЗ-ийн үүрэг, хариуцлага	4.16
	Нийт дундаж	4.36

2025 оны үйл ажиллагааны дүнгээс харахад ТУЗ-ийн үйл ажиллагаа нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнадаг, ТУЗ-ийн гишүүд сонирхолын зөрчилтэй асуудлаар тухай бүр илэрхийлдэг зэрэг нь өндөр оноо авсан нь ТУЗ-ийн сайн засаглал, төлөвшсөн менежмент, хариуцлагатай хандлагыг харуулж байна.

6. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ:

Компанийн хугацаат тайлан, тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл засаглалын баримт бичгийг СЗХ, МХБ, компанийн сайтаар дамжуулан холбогдох журамд заасан хугацаанд нийтэд мэдээлж компанийн ил тод байдлыг ханган ажиллаа. Мөн гаднын хөрөнгө оруулагчид хүргүүлдэг тайлангийн холбогдох мэдээллийг бэлтгэн холбогдох нэгжид хүргүүлээ. СЗХ-оос шинэчлэн



баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын хүрээнд тус кодексийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутам СЗХ, МХБ-д шинэчлэн хүргүүлж хянан баталгаажуулж засаглалын зэрэглэл тогтоолгон ажиллаж байна.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

АЖЛЫН АЛБАНЫ ТАЙЛАН

(ТУЗ-ийн нарийн бичгийн дарга тайлан)

ТУЗ-ийн ажлын алба /цаашид “Ажлын алба” гэх/ нь Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-д компанид хэрэгжүүлж байгаа засаглалын бодлогыг төгөлдөржүүлэх, хэрэгжүүлэх, хянах, сайжруулахад оролцож, ТУЗ ба Гүйцэтгэх удирдлага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог дэмжин ажиллах зорилгын хүрээнд ТУЗ-ийн нарийн бичгийн даргын дараах чиг үүргийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Компани дахь компанийн засаглалын талаарх бодлого боловсруулахад оролцох;
- Компанийн засаглалын бодлогыг бүх түвшний ажилтнуудад дагаж мөрдөх үйл явцыг удирдан чиглүүлж ажиллах; Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах;
- ТУЗ-ийн үйл ажиллагаа (үүнд ТУЗ-ийн дэргэдэх хороод багтана)-г зохион байгуулах, бичиг хэргийг хөтлөх;
- Хувьцаа эзэмшигч ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын хоорондох үр дүнтэй харилцаа холбоог ханган ажиллах;
- Компанийн тухай мэдээллийг ТУЗ-с батлагдсан журмын дагуу хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, олон нийт болон бусад оролцогч талуудад хүргүүлж мэдээлэх;
- Компанийн засаглалын асуудлаар ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад зөвлөх;
- Нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлаар хувьцаат компанид хамааралтай холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллах.

Үйл ажиллагааны голлох үр дүн

Ажлын алба нь тус жилд үндсэн чиг үүргийн дагуу ажил үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ олон улсын болон дотоодын компанийн сайн засаглалын туршлагыг үйл ажиллагаандаа хэвшүүлэхэд анхааран ажиллаа.

Санхүүгийн зохицуулах хороо /цаашид хороо гэх/ шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын хүрээнд тус кодексийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутам СЗХ, МХБ-д шинэчлэн хүргүүлж хянан баталгаажуулж засаглалын зэрэглэл тогтоолгон ажиллаж байна.

Хурал зохион байгуулах ажлын хүрээнд:

Хурлын хүсэлт шийдвэрлэсэн байдал:

Нийт 62 хурлын хүсэлт шийдвэрлэсэн байна. Үүнээс “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хуралд хамаарах 9 хүсэлт, “МИК ОССК” ХХК-ийн хуралд хамаарах 28 хүсэлт, Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны хуралд хамаарах 11 хүсэлт, Санхүү, аудитын хорооны хуралд хамаарах 5 хүсэлт, Эрсдэлийн удирдлагын хороонд хамаарах 6, Тогтвортой хөгжлийн хороонд хамаарах 3 хүсэлтийг тус тус шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

- “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал; (СЗХ-с тус хурлын баримт бичгийг хянаж, хууль, журмын дагуу хуралдуулсан тухай албан ёсоор мэдэгдсэн)
- “МИК ОССК” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал;
- “МИК Рийл Эстэйт” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал;
- Тусгай зориулалттай компаниудын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлууд. (ТУЗ-ийн шийдвэрийн дагуу нийт 39 удаагийн хурал)



ТУЗ-ийн хурал

- “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн 10 хурал
- “МИК ОССК” ХХК-ийн ТУЗ-ийн 11 хурал

“ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурал

Нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хороо, Санхүү, аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо болон Тогтвортой хөгжлийн хорооны нийт 16 удаагийн хурал.

Шийдвэрийн хэрэгжилт:

ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын шийдвэрийн хэрэгжилтийг холбогдох нэгжээс тайлбарыг авч ТУЗ-д танилцууллаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бусад

2026.03.02-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагын багийн хамтарсан компанийн өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцох чөлөөт хэлэлцүүлгийн зохион байгууллаа.

Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх ажлыг зохион байгуулан ажиллаа.

